



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 5-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/14/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Дархан-Уул аймаг
2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: **С.Батцэцэг**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Дундманхайдай аудит”

ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Утас: 91991462

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

ДАРХАН СУМЫН 5 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
О.НАНДИН-ЭРДЭНЭ ТАНАА

2022.02.25 № 154
танай -ны № -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.МӨНХБАЯР



003020225

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	48,654,056.39	41,340,368.39
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,530,059,140.37	1,483,512,540.64
	Нийт хөрөнгийн дүн	1,578,713,196.76	1,524,852,909.03
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,578,713,196.76	1,524,852,909.03
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,578,713,196.76	1,524,852,909.03
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	716,786,669.00	639,585,202.50
	Үйл ажиллагааны зардлын дүн	690,140,835.10	686,049,512.23
	Үйл ажиллагааны үр дүн	26,645,833.90	(46,464,309.73)
	Үйл ажиллагааны бус үр дүн		(7,395,978.00)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	26,645,833.90	(53,860,287.73)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,588,592,125.86	1,578,713,196.76
	Тайлант оны үр дүн	(9,878,929.10)	(53,860,287.73)
	Эцсийн үлдэгдэл	1,578,713,196.76	1,524,852,909.03
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	628,782,900.00	610,225,700.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	626,807,900.00	610,225,700.00
	Үйл ажиллагааны ЦМГ	1,800,000.00	
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	1,800,000.00	
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	612,437,100.00	598,475,248.54
	Урсгал зардал	612,437,100.00	598,475,248.54
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	612,437,100.00	598,475,248.54
	Улсын төсвөөс	574,702,700.00	563,761,786.76
	Орон нутгийн төсвөөс	37,734,400.00	34,713,461.78

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Дархан сумын 5-р цэцэрлэгийн эрхэм зорилго нь: Сургалтын явцад хүүхдийн бие даан суралцах чадварыг нэмэгдүүлэн ахиц гаргах, багш нарын цахим хэрэглээг сайжруулж хэрэгжүүлэх, эцэг эхийн дунд олон талт хамтын үйл ажиллагааг чанартай зохион байгуулж тэдний үүрэг хариуцлага оролцоог нэмэгдүүлнэ.

ЗОРИЛТ:

- Хүүхдийн тоглонгоо суралцах орчин нөхцөлийг бүрдүүлэн тэднийг бие даан суралцахад дэмжлэг үзүүлж, сургалт үйл ажиллагааг хүүхэд бүрд тэгш хүртээмжтэй, чанартай зохион байгуулж, чанарын ахиц гаргах
- Теле хичээлийг чанаржуулж хүртээмжийг нэмэгдүүлэх, үр дүнг тооцож ажиллах
- Багш нарын ажлын байранд цахим программ эзэмших чадварыг хөгжүүлж, хэрэглээ болгох
- Багаар хамтран ажиллаж “ЧАДВАРЛАГ БАГ” бүрдүүлэн хэрэглэгдэхүүний цахим санг сайжруулж баяжуулан сургалт үйл ажиллагаанд ашиглах
- “ДАРХАН-444” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж хүүхдийн хөгжлийг дэмжсэн, эцэг эхийн үүрэг хариуцлага оролцоог нэмэгдүүлсэн үйл ажиллагааг чанартай зохион байгуулж үр дүнг тооцох
- Хамран сургах тойргийн хүүхдийн судалгааг үнэн бодитой хийж хөгжлийн бэрхшээлтэй, зорилтот болон 5 хүртэлх насны хүүхдийг бүрэн хамруулж сургуульд бэлтгэн оруулах

Дархан-Уул аймгийн Дархан сумын 13-р багийн харьяа 2-5 насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, Санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол

Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол

Сангийн сайдын 2021 оны 190 тус тус шинээр мөрдөгдөж эхэлсэн байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Дархан-Уул Дархан сумын 5-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 148 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээлэл хугацаа хоцроосон, 5.0 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын 5,992.1 мянган төгрөгийн 1 ажил, гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалттай нийцээгүй эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд зөвлөмж өглөө

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд ашиглаж байгаа боловч үлдэх өртөггүй 43,424.7 мянган төгрөгийн 86 нэр төрлийн хөрөнгө болон бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 15 нэр төрлийн 14,582.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгааг холбогдох байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлүүлсэн байдал, улсын бүртгэлийн гэрчилгээнд 691,913.2 мянган төгрөгөөр дүрмийн санг нэмэгдүүлж хөрөнгийг шийдвэрлэсэн байдал зэрэгт дараагийн аудитаар хяналтыг хэрэгжүүлнэ.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 12,038.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,445.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,374.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6,217.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

1. Тайлант хугацааны үр дүнгийн тайланд хандиваар авсан хөрөнгийн орлого 3,305.9 мянган төгрөг бүртгээгүй тайлагнасныг залруулав.
2. Мөнгөн хөрөнгийн 140.0 мянган төгрөгийн гүйлгээний дансны бичилтийн алдааг залруулав.
3. Тайлант хугацаанд татварын албанд бүртгэлтэй хуримтлагдсан 2,374.9 мянган төгрөгийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос суутгасан татварын авлага үүсгэж тайланд бүртгэлд тусгаагүй байна.
4. Цалин бодолтыг шалгахад 1 албан хаагчид нийт 25.1 мянган төгрөгийн ХХОАТ-ыг илүү суутгаж, гарт олгох цалинг дутуу олгосон байна.
5. Мөнгөн хөрөнгийн гүйлгээг шалгахад Б.Мөнхөөгийн Шүүхийн шийдвэрээр төлөх 200.0 мянган төгрөгийн төлбөрийг цалингаас суутгал хийгээгүй шилжүүлсэн байна.
6. Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын 5,992.1 мянган төгрөгийн 1 ажил, гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй байна.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	6	12,038.0	2	3,445.9	1	2,374.9	-	-	3	6,217.2
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	6	12,038.0	2	3,445.9	1	2,374.9	-	-	3	6,217.2

